



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

16100 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо,
Утас/Факс: (976) 7000 7636, И-мэйл: info@rtdc.gov.mn,
Вэбсайт: www.rtdc.gov.mn

2022.10.20 № 1/1069
танай _____-ны № _____-т

АВТО ЗАМЫН САЛБАРЫН НИЙТ ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН АЖИЛТАН, БАРИЛГА, ЗУРАГ
ТӨСӨЛ, ЗАСВАРЫН КОМПАНИУД, ИХ ДЭЭД
СУРГУУЛЬ, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДОД

Санал авах тухай

“Авто замын норм, нормативын сангийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан доорх нэр бүхий зөвлөх үйлчлэгээний ажилд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн шууд худалдан авах болсон тул сонирхсон хувь хүн, аж ахуй нэгж байгууллагууд саналаа, чадамжийн талаарх товч танилцуулгын хамт 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор тус төвийн 101 тоотод ирүүлнэ үү. Үүнд

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	ASTM D 7830 SDG 200 “Цахилгаан соронзон орноор талбайн далан суурийн материалын нягт тодорхойлох” стандартыг орчуулан боловсруулах	18 315 000 сая
2	DIN EN 12697-22 “Дугуй мөрний ховилын туршилтын техникийн шаардлага” стандартыг орчуулан боловсруулах	17 088 500 сая
3	AASHTO T343-12 PQI 380 “Цахилгаан соронзон орноор асфальтбетон хучилтын нягт тодорхойлох” стандартыг орчуулан боловсруулах	18 700 000 сая

Ажлын даалгаврыг хавсаргав.

Хавсралт 9 хуудас

ЗАХИРАЛ  Х.ПҮРЭВЖАРГАЛ

БАТЛАВ.

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ



**DIN EN 12697-22 “ДУГУЙ МӨРНИЙ ХОВИЛЫН ТУРШИЛТЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА”
СТАНДАРТЫГ ОРЧУУЛАН БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны 10 сарын 13-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага
 - MNS 6894:2021 “Дугуй мөрний ховил тодорхойлох” стандартын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэн туршилтын үр дүнг боловсруулсан ч харьцуулах техникийн шаардлага байхгүйн улмаас үр дүнг эцсийн байдлаар үнэлэх боломжгүй байна. Иймд DIN EN 12697-22 “Дугуй мөрний ховилын туршилтын техникийн шаардлага” стандартыг орчуулан боловсруулах шаардлагатай байна.
2. Зөвлөх үйлчилгээний зорилго
 - Иймд DIN EN 12697-22 “Дугуй мөрний ховилын туршилтын техникийн шаардлага” стандартыг боловсруулан үндэсний стандартыг орчуулан боловсруулж батлуулах.
3. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ
 - Авто замын салбарт мөрдөгдөх дугуй мөрний ховилын туршилтын техникийн шаардлагатай болох.
4. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд
 - Авто замын салбарт мөрдөгдөж буй асфальтбетон хольц болон асфальтбетоны холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд
5. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат
 - Эхлэл буюу судалгаа, орчуулгын тайлан
 - Эцсийн буюу стандартын төсөл, тайлан, батлагдсан стандарт

6. Зөвлөх үйлчилгээний ажил, үүрэг

- Стандартыг орчуулан боловсруулах
- Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ижил төстэй болон холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийж, уялдуулах, зөрчилдөж буй асуудлыг тодорхойлох
- Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, туршилт шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, зөвлөх инженерүүдээс албан бичгээр санал, шүүмж авч төсөлд тусгах
- Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан 1-ээс доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж төсөлд санал авах.
- Шаардлагатай засвар өөрчлөлтийг тусгасан стандартын эцсийн төсөл, зөвлөх үйлчилгээний ажлын тайланг Захиалагчид танилцуулах
- Стандарт хэмжил зүйн газрын Авто замын салбарын Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулах.

7. Зөвлөх үйлчилгээний баримт бичгийн бүрдэл

- Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ижил төстэй болон холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийж уялдуулах.

8. Зөвлөх үйлчилгээний үр дүн

- Гадаад орны стандартыг орчуулан боловсруулан Монгол улсын үндэсний стандарт болгон батлуулсан байна.

9. Зөвлөх үйлчилгээний онцгой нөхцөл

- Захиалагчид батлагдсан стандартын эх хувийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх
- Стандартыг салбарт сурталчлах товч танилцуулга бэлтгэх

10. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр

- “Авто замын норм нормативын сан”
- 17 088 500 төгрөг

11. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа

- 6 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)

12. Захиалагч байгууллага

- “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ

13. Гүйцэтгэх байгууллага

- Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий судлаачдаас бүрдсэн “Судалгааны баг”

14. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх багт тавигдах шаардлага

- Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий Зөвлөх баг болон хуулийн этгээд байна.

Хянасан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга бөгөөд "Авто замын норм нормативын сан"-гийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.БАЗАРСАД


Боловсруулсан:

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн эрхлэгч



Т.БАТБОЛД

Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн инженер



Л.НЭРГҮЙ



ASTM D 7830 SDG 200 “ЦАХИЛГААН СОРОНЗОН АРГААР ДАЛАН СУУРИЙН НЯГТ БОЛОН ЧИЙГ ТОДОРХОЙЛОХ” СТАНДАРТЫГ ОРЧУУЛАН БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 10 сарын 13-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

- Япон улсын ЖАЙКА байгууллагаас манай улсад хэрэгжүүлж буй “Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд цахилгаан соронзон аргаар далан суурийн нягт тодорхойлох SDG 200 багаж нийлүүлэгдсэн. Багажийг ашиглах ASTM D 7830 SDG 200 “Non-nuclear soil density gauge” стандарт нь манай улсад батлагдаагүй тул уг багажыг ашиглах боломжгүй байна.
- Энэ стандартыг нэвтрүүлснээр далан суурийн нягтыг шинэ дэвшилтэт багаж ашиглан лабораторийн туршилт шинжилгээний хариу хүлээлгүй шууд газар дээр нь тодорхойлох боломжтой болно.

2. Зөвлөх үйлчилгээний зорилго

- “ASTM D 7830 SDG 200 “Non-nuclear soil density gauge” буюу “Цахилгаан соронзон орноор талбайн нягт тодорхойлох” стандартыг боловсруулж, батлуулах, холбогдох багаж төхөөрөмжийг ашиглах эрх зүйн байдлыг шийдвэрлэх, авто замын салбарт ашиглан нэвтрүүлэх.

3. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд

- Авто замын салбарт мөрдөгдөж буй, далан, суурийн нягт шалгах холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд
- Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1.1-2006, MNS 1.2-2006 стандартын дагуу боловсруулах

- | | |
|---|---|
| <p>4. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат</p> | <ul style="list-style-type: none"> • Эхлэл буюу судалгаа, орчуулгын тайлан • Эцсийн буюу стандартын төсөл, тайлан, батлагдсан стандарт |
| <p>5. Зөвлөх үйлчилгээний ажил, үүрэг</p> | <ul style="list-style-type: none"> • “ASTM D 7830 SDG 200-Цахилгаан соронзон орноор талбайн нягт тодорхойлох стандартыг орчуулан боловсруулах • Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ижил төстэй болон холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийж, уялдуулах, зөрчилдөж буй асуудлыг тодорхойлох • Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, туршилт шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, зөвлөх инженерүүдээс албан бичгээр санал, шүүмж авч төсөлд тусгах • Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан 1-ээс доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж төсөлд санал авах. • Шаардлагатай засвар өөрчлөлтийг тусгасан стандартын эцсийн төсөл, зөвлөх үйлчилгээний ажлын тайланг Захиалагчид танилцуулах • Стандарт хэмжил зүйн газрын Авто замын салбарын Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулах. |
| <p>6. Зөвлөх үйлчилгээний үр дүн</p> | <ul style="list-style-type: none"> • “ASTM D 7830 SDG 200” Цахилгаан соронзон аргаар талбайн нягт тодорхойлох” стандартыг орчуулан боловсруулан Монгол улсын үндэсний стандарт болгон батлуулсан байна. |
| <p>7. Зөвлөх үйлчилгээний онцгой нөхцөл</p> | <ul style="list-style-type: none"> • Захиалагчид батлагдсан стандартын эх хувийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх • Стандартыг салбарт сурталчлах товч танилцуулга бэлтгэх |
| <p>8. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр</p> | <ul style="list-style-type: none"> • “Авто замын норм нормативын сан” • 18.315.000 төгрөг |
| <p>9. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа</p> | <ul style="list-style-type: none"> • 6 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш) |
| <p>10. Захиалагч байгууллага</p> | <ul style="list-style-type: none"> • “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ |

11. Гүйцэтгэх байгууллага

- Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий судлаачдаас бүрдсэн “Судалгааны баг”

Хянасан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга бөгөөд “Авто замын норм нормативын сан”-ийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.БАЗАРСАД

Боловсруулсан:

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн эрхлэгч



Т.БАТБОЛД

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн инженер *Ц.Бумбанцагаан* Ц.БУМБАНЦАГААН

БАТЛАВ
“ЗАМ, ТЭЭВРИЙН, ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ

AASHTO T343-12 PQI 380 “ЦАХИЛГААН СОРОНЗОН АРГААР АСФАЛЬТБЕТОН ХУЧИЛТЫН НЯГТ ТОДОРХОЙЛОХ” СТАНДАРТЫГ ОРЧУУДАН БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 10 сарын 13-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага

- Япон улсын ЖАЙКА байгууллагаас манай улсад хэрэгжүүлж буй “Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд цахилгаан соронзон аргаар асфальтбетон хучилтын нягт тодорхойлох багаж нийлүүлэгдсэн. Холбогдох ASTM T343-12PQI 380 Цахилгаан соронзон аргаар асфальтбетон хучилтын нягт тодорхойлох стандарт нь манай улсад батлагдаагүй ашиглах боломжгүй байна.

- Энэ стандартыг нэвтрүүлснээр асфальтбетон хучилтын нягтыг шинэ дэвшилтэт багаж ашиглан лабораторийн туршилт шинжилгээний хариу хүлээлгүй шууд газар дээр нь тодорхойлох боломжтой болно.

- Хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй аргаар буюу цахилгаан соронзон долгион ашиглан туршилтыг явуулна.

2. Зөвлөх үйлчилгээний зорилго

- Цахилгаан соронзон аргаар асфальтбетон хучилтын нягт тодорхойлох үндэсний стандарттай болох.

3. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ

- Авто замын салбарт мөрдөгдөх асфальтбетон хучилтын нягт тодорхойлох техникийн шаардлагатай болох.

4. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд

- Авто замын салбарт мөрдөгдөж буй, далан, суурийн нягт шалгах холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд
- Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт

MNS 1.1-2006, MNS 1.2-2006 стандартын дагуу боловсруулах

- 5. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат
 - Эхлэл буюу судалгаа, орчуулгын тайлан
 - Эцсийн буюу стандартын төсөл, тайлан, батлагдсан стандарт

- 6. Зөвлөх үйлчилгээний баримт бичгийн бүрдэл
 - Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ижил төстэй болон холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийж, уялдуулах

- 7. Зөвлөх үйлчилгээний ажил, үүрэг
 - Стандартыг орчуулан боловсруулах
 - Авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ижил төстэй болон холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийж, уялдуулах, зөрчилдөж буй асуудлыг тодорхойлох
 - Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, туршилт шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, зөвлөх инженерүүдээс албан бичгээр санал, шүүмж авч төсөлд тусгах
 - Төслийн боловсруулалтын явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан 1-ээс доошгүй удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж төсөлд санал авах.
 - Шаардлагатай засвар өөрчлөлтийг тусгасан стандартын эцсийн төсөл, зөвлөх үйлчилгээний ажлын тайланг Захиалагчид танилцуулах
 - Стандарт хэмжил зүйн газрын Авто замын салбарын Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулах.

- 8. Санал болгож буй арга зүй
 - Олон улсад болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөн ашиглагдаж буй асфальтбетон хучилтын нягт тодорхойлох туршилт шинжилгээний талаар судлах

- 9. Зөвлөх үйлчилгээний үр дүн
 - Талбай дээр нь хурдавчилсан, аюулгүй аргаар /цахилгаан соронзон орон ашиглан/ асфальтбетон хучилтын нягтыг тодорхойлох боломжтой болно.
 - Шинэ болон хуучин замд ашиглагдаж буй асфальтбетон хучилтын нягтыг лабораторийн туршилт шинжилгээний хариуг хүлээлгүй инженер техникийн ажилтнууд шинжилгээний хариуг газар дээр нь хурдан харах боломжтой болно.

- Цахилгаан соронзон орон ашиглан асфальтбетон хучилтын нягт тодорхойлох Монгол улсын үндэсний стандарт батлагдсан байна.
 - Жайка төслөөс нийлүүлэгдсэн цахилгаан соронзон орон ашиглан асфальтбетон хучилтын нягт тодорхойлох багажийг хээрийн болон явуулын лабораторийн туршилт шинжилгээний ажилд нэвтрүүлж ашиглаж эхэлсэн байна.
- 10. Зөвлөх үйлчилгээний онцгой нөхцөл**
- Захиалагчид батлагдсан стандартын эх хувийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх
 - Стандартыг салбарт сурталчлах товч танилцуулга бэлтгэх
- 11. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр**
- “Авто замын норм нормативын сан”
 - 18.700.000 төгрөг
- 12. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа**
- 6 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)
- 13. Захиалагч байгууллага**
- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
- 14. Гүйцэтгэх байгууллага**
- Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий судлаачдаас бүрдсэн “Судалгааны баг”

Хянасан:


Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга бөгөөд “Авто замын норм нормативын сан”-гийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.БАЗАРСАД


Боловсруулсан:

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн эрхлэгч



Т.БАТБОЛД

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторийн инженер



Н.АМАРЗАЯА